*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Бараа материалын орлого, зарлагын үзүүлэлт	Дүн
<b>2021 оны эхний үлдэгдэл</b>	<b>259,947.7</b>
<b>Нэмэгдсэн</b>	<b>574,948.1</b>
Худалдан авсан	403,360.3
Хандиваар	127,553.2
Шилжүүлэн авсан	44,034.6
<b>Хасагдсан</b>	<b>538,897.9</b>

Худалдсан, зарцуулсан	508,722.9
Шилжүүлсэн	3,205.0
Бусад	26,970.0
<b>2021 оны эцсийн үлдэгдэл</b>	<b>295,997.9</b>

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,161,118.9 мянга, эцсийн үлдэгдэл 6,547,717.3 мянган төгрөг болж 1,386,598.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	<b>5,090,606.9</b>	<b>6,474,875.3</b>	<b>1,384,268.4</b>	<b>99.99</b>
Барилга байгууламж, орон сууц	3,672,691.5	4,886,899.8	1,214,208.3	75.5
Тээврийн хэрэгсэл	293,774.8	256,114.8	-37,660.0	4.0
Машин тоног төхөөрөмж	555,369.4	685,336.7	129,967.3	10.6
Тавилга эд хогшил	289,094.5	318,822.8	29,728.3	4.9
Номын фонд	22,386.8	26,376.0	3,989.2	0.4
Бусад үндсэн хөрөнгө	237,289.9	301,325.2	64,035.3	4.7
Дуусаагүй барилга	20,000.0	0.0	-20,000.0	0.0
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>70,512.0</b>	<b>72,842.0</b>	<b>2,330.0</b>	<b>100.00</b>
Программ хангамж	2,270.00	4,600.00	2,330.00	6.3
Бусад биет бус хөрөнгө	68,242.00	68,242.00	0.00	93.7
<b>НИЙТ ДҮН</b>	<b>5,161,118.9</b>	<b>6,547,717.3</b>	<b>1,386,598.4</b>	<b>100.00</b>

*Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 1,150,144.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 96.5 хувь буюу 1,394,306.6 мянган төгрөгийг хөрөнгийн хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна. Үүнд: ЗДТГ нь Гурванбулаг сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн 6/03 дугаар тогтоолоор 41758.9 мянган төгрөгийн хөрөнгө, Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2021.06.07-ны өдрийн 01/594 дугаар албан бичиг 4,272.6 мянган төгрөгийн өртөг бүхий "Хур систем"-ийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан, мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200 хүний суудалтай 1,1393,160.4 мянган төгрөгийн өртөг бүхий соёлын төвийн барилга ашиглалтад орж улсын комисс хүлээн авч хөрөнгийн бүртгэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	3,905.6	4,374.0	468.4	0.09
ЗДТГ	1,242,350.1	1,209,731.5	-32,618.6	23.87
Соёл	66,308.6	1,266,518.0	1,200,209.5	24.99
ЭМТ	458,741.9	514,266.2	55,524.3	10.15
ЕБС	1,289,121.5	1,224,978.1	-64,143.4	24.17
Цэцэрлэг	857,946.0	848,375.0	-9,570.9	16.74
<b>НИЙТ ДҮН</b>	<b>3,918,373.6</b>	<b>5,068,242.9</b>	<b>1,149,869.3</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тухайн онд 49,951.7 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 82,004.1 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 1,306,987.5 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, бусад байдлаар 5,315.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Мөн сумын ИТХ-ын 2020.04.10-ны өдрийн 13 дугаар тогтоолоор ЗДТГ-т бүртгэлтэй 37660.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг дуудлага худалдаанд оруулж, данснаас хассан, мөн 20,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий дуусаагүй барилгыг данснаас хасаж, бусад үндсэн хөрөнгөд бүртгэгдсэнтэй холбоотой байна.

**Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/**

Нэмэгдсэн	1,444,258.3	Хасагдсан	57,660.0
Худалдан авсан	49,951.7	Худалдсан	
Хандиваар	82,004.1	Акталсан	37,660.0
Шилжүүлэн авсан	1,306,987.5	Шилжүүлсэн	20,000.0
бусад	5,315.0	Бусад	

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,859.9 мянга, эцсийн үлдэгдэл 93,247.0 мянган төгрөг болж 89,387.1 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	<b>3,859.9</b>	<b>93,247.0</b>	<b>89,387.1</b>	<b>100.0</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	5,500.0	5,500.0	5.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	89.1	0.0	-89.1	0.0
Байгууллагад төлөх өглөг	3,770.8	87,746.9	83,976.1	94.1
<b>БХӨТ-ийн Дүн</b>	<b>3,859.9</b>	<b>93,247.0</b>	<b>89,387.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 93,247.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЭМД-ын санхүүжилт дутуу орсонтой холбоотой сумын Эрүүл мэндийн төвийн өглөг 92,964.5 мянган төгрөг буюу 99.7 хувь, ЗДТГ-ын байгууллагад өгөх өглөг 0.3 хувийг эзэлж байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.

**Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЗДТГ	0	282.5	↑ 282.5	0.3
Соёл	1868.1	0.0	↓ -1868.1	0.0
ЭМТ	1963.6	92964.5	↑ 91000.8	99.7
ЕБС	28.1	0.0	↓ -28.1	0.0
<b>БХӨТ-ийн дүн</b>	<b>3859.9</b>	<b>93247.0</b>	<b>89,387.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**3.5.9 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,660,883.4 мянга, эцсийн үлдэгдэл 6,228,857.7 мянган төгрөг болж, 1,567,974.3 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 12. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,852,532.3	1,852,532.3	0.0	29.7
Хуримтлагдсан үр дүн	2,214,527.9	3,782,502.2	1,567,974.3	60.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	593,823.2	593,823.2	0.0	9.5
<b>Цэвэр хөрөнгийн дүн</b>	<b>4,660,883.4</b>	<b>6,228,857.7</b>	<b>1,567,974.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн данс 1,567,974.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,568,974.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой бөгөөд үүнд сумын ИТХ-ын 1,000.0 мянган төгрөгийн авлагыг данснаас хассантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.15-ний өдрийн хуралдаанаар 2/02 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 102,500.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3,000.0 мянга, нийт 105,500.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
ИОТХ	12,500.0	14,503.0	2,003.0	116.0
хадгаламжийн хүүгийн орлого	34,000.0	100727	11,229.5	133.0
ҮХЭХ борлуулсны албан татвар	3,000.0	2,090.0	(910.0)	69.7
Бууны татвар	4,000.0	3,176.7	(823.3)	79.4
Улсын тэмдэгт	1,500.0	1,144.0	(356.0)	76.3
Газрын төлбөр	2,000.0	5,545.3	3,545.3	277.3
Ан агнуур	-	109,209.6	109,209.6	
Ус рашаан	-	-	-	
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	10,000.0	7,947.3	(2,052.7)	79.5
ТТАМАТөлбөр	500.0	1,240.0	740.0	248.0
Малын тоо толгойн татвар	35,000.0	36,693.1	1,693.1	104.8
Бусад татвар	-	15,481.4	15,481.4	
<b>Татварын орлого</b>	<b>102,500.0</b>	<b>242,259.9</b>	<b>139,759.9</b>	<b>236.4</b>
<b>Татварын бус орлого</b>	<b>3,000.0</b>	<b>7,732.5</b>	<b>4,732.5</b>	<b>257.8</b>
<b>Нийт орлогын дүн</b>	<b>105,500.0</b>	<b>249,992.4</b>	<b>144,492.4</b>	<b>236.4</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 144,492.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 2,003.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 11,229.5 мянга, газрын төлбөр 3,545.3 мянга, ан агнуурын орлогыг 109,209.6 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг 740.0 мянга, малын тоо толгойн татварыг 1,693.1 мянга, бусад татварыг 15,481.4 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг 910.0 мянга, бууны албан татварыг 823,3 мянга, улсын тэмдэгтийн хураамжийг 356.0 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг 2,052.7 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 367.5 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

#### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,464,470.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,198,305.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 2,125,614.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 72,690.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн

системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.15-ний өдрийн 2/02 дугаар тогтоолоор нийт 2,456,742.2 мянган төгрөгийг баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.15-ний өдрийн 2/02 дугаар тогтоолоор анх 2,456,742.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.29-ний өдрийн 4/01 дугаар тогтоолоор 5,678.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 2,050.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,462,420.0 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,413,692.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 96,789.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 632,671.0 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 56,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 22,185.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 129,903.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 71,158.7 мянган төгрөгөөр дутуу, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 6,528.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 66,925.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улс	ОН
Засаг даргын Тамгын газар	431,503.6	421,970.3	9,533.3	97.8	-	8,900.8
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	79,622.5	79,360.4	262.1	99.7	-	29.1
Соёлын төв	109,696.6	105,851.4	3,845.2	96.5	-	3,845.2
Сум хөгжүүлэх сан	109,903.5	51,200.0	58,703.5	46.6	-	-
Сургууль	844,163.8	747,056.6	97,107.2	88.5	45,850.7	-
Цэцэрлэг	298,995.9	271,347.8	27,648.1	90.8	20,756.2	-
Эрүүл мэндийн төв	455,678.1	448,828.6	6,849.5	98.5	318.8	-
Орон нутгийн хөгжлийн сан	134,906.3	72,690.2	62,216.1	53.9	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2,464,470.3</b>	<b>2,198,305.2</b>	<b>266,165.07</b>	<b>89.2</b>	<b>66,925.7</b>	<b>12,775.1</b>

*Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 9,533.0 мянга, ИТХ-ын төсвийг 262.1 мянга, Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 97,107.2 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардал 27,648.1 мянга, Эрүүл мэндийн төвийн төсвийг 6,849.5 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 62,216.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 124,081.9 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 39,992.7 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 48,657.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 24,318.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх

дэмжлэг 21,737.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 109,370.3 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид 24,318.5 мянга, хөрөнгийн зардалд 5,867.5 мянган төгрөг нийт 195,468.6 мянган төгрөгийг зарцуулж 17,263.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	Соёл	НИИТ
<b>НИИТ ОРЛОГО</b>	<b>1,000.0</b>	<b>48,855.3</b>	<b>19,959.0</b>	<b>3,550.8</b>	<b>132,786.5</b>	<b>6,580.0</b>	<b>212,731.6</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.00	18,789.1	19,309.0	3,550.8	81,433.0		124,081.9
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		30066.2	650.0		2696.5	6,580.00	39,992.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого					48657.0		48,657.0
<b>НИИТ ЗАРЛАГА</b>	<b>999.8</b>	<b>31,770.4</b>	<b>19,781.0</b>	<b>3,550.8</b>	<b>132,786.6</b>	<b>6,580.0</b>	<b>195,468.6</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	999.80	31770.4	650	3550.8	65819.3	6580.0	109,370.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			19,131.0		61,099.8		24,318.5
Хөрөнгийн санхүүжилт					5,867.5		5,867.5
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	<b>0.15</b>	<b>17,084.80</b>	<b>178.04</b>	<b>0</b>			<b>17,263.0</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 53,168.9 мянга, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд 6,000.0 мянга, гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгааны зардалд 28,570.7 мянган төгрөгийг тодотгон баталж, гүйцэтгэлээр 84193.7 мянган төгрөгийг зарцуулж, 3,545.9 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 84 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,464,470.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,198,305.2 мянган төгрөгийг зарцуулж, 89.2 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 10 нэр төрлийн орлогоор 105,500.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 249,992.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 236.4 хувь буюу 144,492.4 сая төгрөгөөр давж биелсэн боловч 4 нэр төрлийн орлого 4,142.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Гурванбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Гурванбулаг сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЕБСургууль	1	1	1		1		1			
Хүүхдийн цэцэрлэг	1	1	1		1	1				
ЗДТГ	1	1	1		1	1				
ИТХурал	1	1		1						
Соёлын төв	1	1			1					
ЭМТ	1	1	1		1	1				
ОНХС	1	1			1					
СХС	1	1			1					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагуудаас сумын Ерөнхий боловсролын сургуульд хязгаарлалттай дүгнэлт өгч бусад байгууллагуудад зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, байгууллагын эд хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийгээгүй, тооллогын дүнг баталгаажуулаагүй тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болсон байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 268,010.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10,798.9 сая төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 7,518.0 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 157,570.9 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 92,122.1 мянган төгрөгийн 12 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Залруулга		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн зөрчил</b>										
ЕБСургууль	4	5,940.2			2	5736.64	2	203.6		

Хүүхдийн цэцэрлэг	2	2,434.4	1	1,005.0	1	1429.4				
ЗДТГ	6	147,004.4			1	352	2	139307.1	3	7,345.30
ОНХСан	5	22,894.7					1	14552.9	4	8341.8
ЭМТ	7	12,034.9	4	8,527.6			2	3,507.4	1	0
СХС	-	-								
ИТХурал	2	6,508.4	1	1,266.3					1	5242.1
СТА зөрчлийн дүн	26	196,817.1	6	10,798.9	4	7,518.0	7	157,570.9	8	15,687.1
<b>СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
ЕБСургууль	1	-					1	0		
Хүүхдийн цэцэрлэг	-	-								
ЗДТГ	2	-							2	0.00
ИТХурал	-	-								
Соёлын төв	1	-							1	0
ЭМТ	1	71,192.9							1	71,192.9
Нийцлийн аудитын дүн	5	71,192.9	0	0	0	0	1	0	4	71,192.9
Нийт дүн	31	268,010.0	4	10,798.9	4	7,518.0	8	157,570.9	12	92,122.1

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 196,817.1 мянган төгрөгийн 26 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 71,192.9 мянган төгрөгийн 4 зөрчил тус тус илэрсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

дд	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	11	1	
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	59	1	
5	Тухай бүр	6	72	71	1	

Нийт дүн	28	155	152	3
----------	----	-----	-----	---

Эх сурвалж. Гурванбулаг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Гурванбулаг сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Гурванбулаг сумын ЗДТГ нь 2021 оны төсвийг 400,773.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 30,730.1 мянган төгрөг нэмж 430,503.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 421,970.3 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 8,900.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 2.1 хувийг хэмнэсэн нь төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд дээрх зөрчилд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах **зөвлөмжийг** хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 29,835.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ний өдрийн 245 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	2	0	0	0			100.0
Нийт	2	0	0	0			100.0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй 4 зөвлөмжийг хүргүүлж байна.

### 4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх.

## 2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.15-ний өдрийн 2/02 дугаар тогтоолоор анх 2,456,742.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.29-ний өдрийн 4/01 дугаар тогтоолоор 5,678.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 2,050.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байхад нэмж тодотгоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж, зарцуулах эрхийг нээж байх.

## 3. 1.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Тус сумын Орон нутгийн ерөнхий орлогын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 250,359.9 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст мэдээлэхдээ 251,589.9 мянган төгрөг буюу 1230.0 мянган төгрөгөөр хог хаягдлын хураамжийг илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

## 4. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллээс 1, сар бүр мэдээлэх мэдээллээс 1, бүтэн жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 1 мэдээллийг тус бүр хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

**Гурванбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
	Гурванбулаг сумын ТТЗ	3	1,230.0							3	1,230.0
<b>Дүн</b>		3	1,230.0							3	1,230.0
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
	Гурванбулаг сумын ТТЗ	1	0							1	0
<b>Дүн</b>		1	0							1	0
<b>Нийт дүн</b>		4	1,230.0							4	1,230.0

**6. Хавсралт 1: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Гурванбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
2021			БНА-2021/1/СТА-ТТЗ		
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		Гурванбулаг сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
A	1	2	3	4	5
1	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.	0	Зөвлөмж	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тогтожаргал
2	Тус сумд тусгай зориулалтын шилжүүлгээс олгох санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжаар сумын ЕБС-ийн төсвийг 650.0 мянга, цэцэрлэгийн төсвийг 1400.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн ч сумын ИТХ-ын тогтоолоор нэмж тодотгоогүй байна.	0	Зөвлөмж	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тогтожаргал
3	Тус сумын ОНЕО-ын дансанд сумд төвлөрөх татварын орлогоор 250,359.9 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст мэдээлэхдээ 251,589.9 мянган төгрөг буюу 1230.0 мянган төгрөгөөр хог хаягдлын хураамжийг илүү мэдээлсэн байна.	1230.0	Зөвлөмж	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тогтожаргал
4	Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллээс 1, сар бүр мэдээлэх мэдээллээс 1, бүтэн жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 1 мэдээллийг тус бүр хугацаа хоцроож мэдээлсэн байна	0	Зөвлөмж	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тогтожаргал
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дүн</b>		<b>1230.0</b>			
<b>Харьяа төсвийн байгууллагуудын дүн</b>		<b>268,010.0</b>			
<b>Цэцэрлэг</b>		<b>2434.4</b>			
5	Ажиллагсдын цалингаас суутгасан ХХОАТ-ын 1429.4 мянган төгрөгийг төсвөөс илүү төлж авлага үүсгэсэн байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэснийг зөрчсөн	1429.4	Төлбөрийн акт	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Цэрэнханд, Ж.Дорждагва
6	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1005.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг НББ-д орлого авч үлдэгдлээр тусгасан байхад нярвын	1005.0	Санхүүгийн тайланд	Эрхлэгч, нягтлан бодогч	Э.Цэрэнханд, Ж.Дорждагва

**Гурванбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	тайланд орлого аваагүй, тооллогоор үлдэгдлээр тоологдсон байна.		залруулав.		
<b>Сургууль</b>		<b>5,940.2</b>			
7	Байгууллагын тооллогын комисс нь эд хөрөнгийг данс бүрээр хөрөнгийн журналаар тоолоогүй, ажилтнуудын картаар тоо ширхгээр тоолсон нь бүртгэлтэй хөрөнгүүдийг ажилтнуудын картад бүрэн бүртгэж тоологдсон эсэхийг нотлох боломжгүй, тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж захирлын тушаалаар баталгаажуулаагүй байна.	0	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Д.Цэцгээ, Ж.Дорждагва
8	Ажиллагсдын цалинг 2021 оны 05, 06, 07, 09 дүгээр саруудад 203.6 мянган төгрөгөөр Нийгмийн даатгалын хэлтэст илүү мэдээлсэн байна.	203.6	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Д.Цэцгээ, Ж.Дорждагва
9	2019 онд нормын хувцас худалдан авахаар "Хөгжил дэвшил нэгдэл" ХХК-д 2519.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ч хөрөнгийг нийлүүлээгүй байхад орлого авч хөрөнгөд бүртгэсэн байна.	2519.0	Төлбөрийн акт	Захирал, нягтлан бодогч	Д.Цэцгээ, Ж.Дорждагва
10	Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2021 онд нийт 1,086,278.8 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 127,519.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроосон, 4-р улирлын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй байна	0	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Д.Цэцгээ, Ж.Дорждагва
11	Цалингийн зардлаас ажилчдаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын хэлтэст 3,217.6 мянган төгрөгөөр илүү шилжүүлэн авлагаар бүртгэж төсөвт зардлыг хэтрүүлсэн.	3217.6	Төлбөрийн акт	Захирал, нягтлан бодогч	Д.Цэцгээ, Ж.Дорждагва
<b>Засаг даргын Тамгын газар</b>		<b>16209.1</b>			
12	Засаг даргын 2021.02.09-ний өдрийн 38 дугаар захирамжаар 2020 оны аймаг сумын аварга малчин, мал аж ахуйн салбарт шалгарсан малчдыг шагнаж урамшуулах 5000.0 мянган төгрөг зарцуулах шийдвэр гарсан ч 352.0 мянган төгрөгийг архинаас гарсан иргэдийг шагнаж урамшуулж зориулалт бусаар зарцуулсан байна.	352.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
13	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь Хаан банкин дахь 5237001000 тоот харилцах дансаар тайлант оны 2021.11.25-ны байдлаар 71,680.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулсан байна.	71680.2	Албан шаардлага	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
14	Тайлант хугацаанд Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгө, байгаль орчныг нөхөн сэргээх зардал болон гамшгаас сэргийлэх, сургалт сурталчилгааны зардлаас зарцуулсан 67,626.9 мянган төгрөгийн зарцуулалтын тайланг гаргаж үр дүнг тооцоогүй байна.	67626.9	Албан шаардлага	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
15	Тайлант хугацаанд 2290.3 мянган төгрөгийн 2 гүйлгээг и баримт болон анхан шатны баримтын бүрдэлгүй, 3721.7 мянган төгрөгийн 16 гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, мөн хувь хүн рүү шилжүүлсэн зарим гүйлгээг 10 хувийг суутгаагүй, зарим сард төрийн санд гүйлгээ хийхдээ нэгдүгээр гарын үсэг зурах эрх бүхий	6012.0	Зөвлөмж өгсөн	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай

Гурванбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	албан тушаалтын гарын үсэггүйгээр гүйлгээ хийсэн байна.				
16	Тайлант хугацаанд аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлаас сонины төлбөрт 87.7 мянга, лицензийн төлбөрт 198.0 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 75.0 мянган төгрөгийн автомашины татвар хураамж, аудит баталгаажуулалтын зардлаас туг далбааны үнэ болох 117.6 мянга, гэрэл цахилгааны зардлаас 605.0 мянган төгрөгийн халаагуурын үнэ, хөдөлмөр хамгааллын зардлаас ЗДТГ-ын жолоочид 250.0 мянган төгрөгийн гутал худалдан авсан байна.	1333.3	Зөвлөмж өгсөн	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
17	Тайлант хугацааны Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулгахад тус сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн 97, 2021 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн 123, 2021 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн 82, 2021 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн 85 дугаар захирамж нь хүчингүй болсон журмыг үндэслэн гаргасан байна.	0	Зөвлөмж өгсөн	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
18	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17,084.8 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроосон байна.	0	Зөвлөмж өгсөн	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
19	2021 оны төсвийг 400,773.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 30,730.1 мянган төгрөг нэмж 430,503.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 421,970.3 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 8,900.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 2.1 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.	0	Зөвлөмж өгсөн	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
<b>Эрүүл мэндийн төв</b>		<b>83227.7</b>			
20	2021 оны 12 дугаар сард Нийгмийн даатгалын хэлтэст 1 ажилтны цалингийн санг 195.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн	195.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав
21	Баянхонгор аймаг дахь Сум дундын шүүхийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний 131/ШШ2021/00171 тоот захирамжаар нягтлан бодогчоор ажиллаж байсан Т.Нарангаравын Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 54 дугаар бүхий тушаалаар ажлаас халагдаад ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн олговорт 3,311.9 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон.	3311.9	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав
22	Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс нийт 71,192.9 мянган төгрөгийн 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна	71192.9	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав
23	Тайлант оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх тооллогын комиссын бүрэлдэхүүнийг байгууллагын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн 82 тоот тушаалаар байгуулсан ба комиссын бүрэлдэхүүнд нягтлан бодогч, нярав нарыг оруулсан байна	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав

Гурванбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
24	Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр худалдан авсан 1,807.6 мянган төгрөгийн эм, ороох боох материалыг бусад хангамжийн материал дээр нягтлан бодогч давхардуулж орлого авсан	1807.6	Санхүүгийн тайланд залруулав	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав
25	Гарт олгох цалингийн өглөгийг үүсгэхдээ өглөгийн дүнгээс авлагыг хассан зөрүүгээр тооцож 1,928.3 мянган төгрөгөөр дутуу тусгасан,	1928.3	Санхүүгийн тайланд залруулав	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав
26	Ажиллагсдад олгосон урьдчилгаа тооцооны авлагыг 430.2 мянган төгрөгөөр илүү тусгасан.	430.2	Санхүүгийн тайланд залруулав	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав
27	2021 оны 9,10 дугаар сарын халаалтын зардал 4,361.4 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардал руу хаасан	4361.4	Санхүүгийн тайланд залруулав	Дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар М.Нарангарав
<b>Орон нутгийн хөгжлийн сан</b>		<b>22,894.7</b>			
28	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн гамшгаас хамгаалах өвс худалдан авах, оготоно устгах ажилтай холбоотой бэлтгэсэн 7465.4 мянган төгрөгийн хөрөнгийг ЗДТГ-т орлого аваагүй.	7465.4	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч	Б.Гантулга, П.Тогтохжаргал, Б.Өлзиймаа
29	Эрчим хүчний шугамын өргөтгөл хийх ажлын хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчээс магадалшгүй ажлын зардал 267427 төгрөгийг суутган тооцоогүй.	267.4	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч	Б.Гантулга, П.Тогтохжаргал, Б.Өлзиймаа
30	Тайлант хугацааны ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХС-аас авах санхүүжилт 96789.6 мянга, урьд оны үлдэгдлээс 3116.6 мянга, орон нутгийн төсвөөс 35000.0 мянган төгрөгөөр бүрдүүлж зарцуулахаар баталсан ба тайлант хугацаанд гүйцэтгэлээр төвлөрсөн өвс тэжээлийн 8550.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	0	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч	Б.Гантулга, П.Тогтохжаргал, Б.Өлзиймаа
31	ОНХС-ийн санхүүгийн тайланд 609.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлага байгаа нь 2018-2019 онд үүссэн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	609	Зөвлөмж өгсөн	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч	Б.Гантулга, П.Тогтохжаргал, Б.Өлзиймаа
32	Мөн санхүүгийн 129.0 сая төгрөгийн малжуулахын авлагын үлдэгдэл байгаагаас 10 хүний 14552.9 мянган төгрөгийн авлага нь 2013-2017 онд үүссэн гэрээний хугацаа дууссан байна.	14,552.9	Албан шаардлага	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч	Б.Гантулга, П.Тогтохжаргал, Б.Өлзиймаа
<b>Соёлын төв</b>					
33	Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 140211.0 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээтэй холбоотой 36,975.0 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	Б.Бадамцэцэг Б.Өлзиймаа
<b>ИТХ</b>		<b>6508.4</b>			
34	Санхүүгийн тайланд цалингийн урьдчилгаа 500.0 мянга, Монгол шуудан ХХК руу илүү шилжүүлсэн 86.8 мянган төгрөгийг авлагаар	1266.3	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	С.Алтанцэцэг Б.Дэлгэрдалай

Гурванбулаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	тусгаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайлан алдаатай татагдсанаас эрүүл мэндийн даатгалын зардал болон бичиг хэргийн зардал 679.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.				
35	Тайлант хугацаанд 5242.1 мянган төгрөгийн 4 гүйлгээг нэгдүгээр гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүйгээр гүйлгээ хийсэн бөгөөд мөн төрийн санд гүйлгээ хийсэн огноо, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулаагүй зарлагын гүйлгээ хийсэн байна	5242.1	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	С.Алтанцэцэг Б.Дэлгэрдалай

оОо